
Living the Lotus 10

Buddhism in Everyday Life


2026
VOL. 253



Энэхүү “Living the Lotus” сэтгүүл маань энэ сард 21 жилийн ойтойгоо золгож байгаа билээ. Энэ хугацаанд бидэнтэй хамт байж, олон талаар тусламж дэмжлэг үзүүлж байсан уншигч та бүхэндээ гүнээ талархал илэрхийлье.

РКК байгууллагын англи хэл дээрх цахим хуудас шинэчлэгдэж байгаатай холбогдуулан тус сэтгүүл ирэх 11-р сараас цахим хувилбарт шилжиж байгааг та бүхэнд мэдэгдэж байна.

Энэ сарын дугаар PDF хувилбарын сүүлийн дугаар болж байгаа боловч цахим хувилбараар сэтгүүлээ үргэлжлүүлэн та бүхэндээ хүргэх тул цаашид ч гэсэн бидэнтэй хамт байгаарай хэмээн хүсэж байна.



Living the Lotus
Vol. 253 (2026.10)

Ахлах редактор: Маэда Такаши
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1
Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамуни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдрал)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Амьдрал ба үхэл нь гайхамшигт хуулийн нэг хэсэг - 1

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Үхэл”-ийг даван туулах

Үүсгэн байгуулагч буддизмын амь насны тухай үзэл, үхэл гэдэг зүйлийн талаар айлдсан айлдвартаа “Бурханы зам мөрийн нэг чухал зорилго бол төрөх, өтлөх, өвдөх, үхэх зовлонгоос гэтлэх юм” гэж хэлсэн байдаг.

“Үхэл” гэдэг хүний амьдралын нэг том хэсэг учраас “хүн үхсэний дараа яадаг юм бол?”, “үхэхээс айж байна”, “үхмээргүй байна” гэсэн айдас түгшүүр хийгээд зовлонг гэтлэх буюу даван туулах нь үнэхээр л бурханы зам мөрийн нэг чухал зорилго болдог. Ийнхүү сэтгэлийн амгаланг олохын зэрэгцээ өөрийн хийгээд өрөөлийн сайн сайхны төлөө бие сэтгэлээ өнгөлөн зүлгэж сайжруулах нь бурханы зам мөр болно.

Энэхүү бурханы зам мөрийн чухал ойлголт болох “амьдрал ба үхэл” гэдгийг бид хэрхэн хүлээж авах хэрэгтэй вэ? Миний хувьд үхэл гэдгийг жишээлбэл “орчлонгийн аугаа амь” хэмээх эх нутаг руугаа буцах явдал, амьдрал гэдгийг онолын физикч эрдэмтэн Сажи Харүо гуайн үгнээс эш татан хүмүүс бидний амь нас бол сансар огторгуйтай нэгэн бүхэл бөгөөд “онолын хувьд бид өдөр бүр мөнх орчлонгийн нэгэн хэсэг болон амьдардаг” гэж тайлбарлаж, амь насны тухай үзлийг та бүхэнд дамжуулж ирсэн.

Цагаан лянхуа сударт сургадагчлан “амь нас” гэдгийг сансар огторгуй талаас нь харах юм бол бидний амь нас орчлон ертөнц үүссэн цагаас авхуулаад ирээдүй рүү үргэлжлэх “мөнх орчлон”-ын нэг хэсэг юм. Ийн хүлээж авах юм бол үхэл гэдэг айдас биш болж, гаслан зовлон, сэтгэлийн шаналал ч гэсэн зөөлрөх болов уу.

Үхэлтэй нүүр тулж, Бурханы хэмжээлшгүй амь насны талаар айлддаг Цагаан лянхуа судрын сүсэг бишрэлийн ачаар амьдрал үхлийн зовлонг даван туулсан хүн гэвэл яруу найрагч Мияазава Кэнжи гэж хэлж болно. Миязава гуай “Би хэзээ нэг өдөр яван одно, өнөөдөр эсвэл маргааш” хэмээн тэрлэсэн шүлэгтээ “Би нас эцэслэснийхээ дараа огторгуйн хоосон руу буцна, тэгээд дахин

өөрийгөө олох буй за... Тэрхүү тулгуур хуулийн нэрийг Гайхамшигт Ном Лянхуа Судар хэмээмүй" гэж бодол санаагаа илэрхийлсэн байдаг. Хүн өөд болсны дараа сансар огторгуй хэмээх аугаа амьтай эргэн нэгдэж, улмаар дахин төрнө гэж Цагаан лянхуа сударт өгүүлдэг гэсэн байна.

Цагаан лянхуа судраар дамжуулж "мөнх орчлон"-той нэгэн бүхэл гэдгээ ухаарч, өвчин зовлонгоо даван туулсан Миязава гуай "Амьдрал бол Гайхамшигт Ном, үхэл ч гэсэн Гайхамшигт Ном" хэмээн үргэлжлүүлэн өгүүлжээ. Өвчин зовлонтой амьдрал ч, ойртон ирж буй үхэл ч гэсэн Гайхамшигт Ном (орчлонгийн хууль) өөрөө гэж хүлээж авсан гэсэн үг биз ээ.

Бид мөнх орчлонтой нэгэн бүхэл

Миязава гуай энэ шүлгийг 1929 оны 2-р сард бичсэн гэхээр өөд болохоосоо 4 жилийн өмнө 33 настай байсан гэсэн үг юм. Ийм залуугаараа амьдрал үхлийн талаар энэ мэт гүнзгий ойлголттой болох хүн ховор. Энэ хэмжээнд хүрэхэд мэдээж хэрэг Цагаан лянхуа судрын сургаал нөлөөлсөн нь дамжиггүй.

Хүн өөд болоод хаашаа явдаг болох, яах эсэхийг хэн ч мэдэхгүй. Гэхдээ л яг одоо ч тэр, нас эцэслэснийхээ дараа ч тэр мөнх орчлонтой нэгэн бүхэл оршно гэхээр сэтгэл тайвширна. Гайхамшигт Ном Лянхуа Судартай учирснаар үүнийг мэдэж авсан Миязаки гуайн баяр баяслыг, ижил сүсэг бишрэлтэй бид ч гэсэн мэдрэх боломжтой биш гэж үү.

Миний хувьд өмнө "Амь насны эх үндэс рүүгээ амар амгалан буцан одсон Үүсгэн байгуулагчийн дүр төрхийг хараад, ингэж сүүлийн мөчтэйгөө нүүр тулах юмсан гэж үхлийн талаар уужуу тайван боддог болсон" гэж хэлж байсан. Энэ бол ухаант мэргэдийн амь насны талаарх сургаал, сүсэг бишрэлийн ач буян билээ.

Үхэл гэдэг хэнийг ч ялгалгүй ирдэг бөгөөд санаанд таарсан үхэл гэж ер нь байхгүй биз. Тийм ч учраас "төрөх, өвдөх, өтлөх, үхэх зовлонг гэтлэх" нь амьдралын томоохон зорилго болох юм. Түүнчлэн хүн бүхэн үхэлтэй нүүр тулах учраас яг одоо амьд мэнд байгаадаа талархаж, тэрхүү "яг одоо" гэсэн цаг хугацаандаа олон хүнтэй нөхөрлөж сайхан амьдрах шиг жаргал үгүй билээ.

Өнөөгийн ертөнц сансар огторгуй үүссэн цаг мөчөөс тасралтгүй үргэлжлэх мөнх орчлонгийн урсгал дунд оршиж байгаа ба бид юуны тулд яг одоо энэ ертөнцөд төрөх, өвдөх, өтлөх, үхэх зовлонг туулан амьдарч байгаа юм бол? Энэ талаар дараагийн дугаарт хамтдаа бодож үзэх болно.


"*Косей*" сэтгүүл, 10-р сарын дугаараас



Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter

A Global Buddhist Movement



Information about local Dharma centers

facebook

X

We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp